



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 4/87

Улаанбаатар хот

МУИС-ийн хурлын танхим ашиглалтын  
журам, гэрээг батлах тухай

Монгол Улсын Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, МУИС-ийн Дүрмийн 4.3.1, 4.3.8.4, МУИС-ийн захиргааны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.МУИС-ийн хурлын танхим ашиглалтын журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Хурлын танхим ашиглалтын гэрээ"-г 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


2.Журам болон гэрээг 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтийг ханган ажиллахыг Хангамж, үйлчилгээний газрын дарга (В.Алтансүх)-д үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төлөвлөлт хариуцсан дэд захирал (Ч.Ундрэм)-д даалгасугай.


5.Журам батлагдсантай холбогдуулан төлбөр хураамжийн хэмжээг Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн тогтоох ажлыг зохион байгуулахыг Санхүү, төлөвлөлт хариуцсан дэд захирал (Ч.Ундрэм)-д даалгасугай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Я.ТӨМӨРБААТАР

Захирлын 2019 оны 02 дугаар сарын 28-ны  
өдрийн 18 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



## МУИС-ИЙН ХУРЛЫН ТАНХИМ АШИГЛАЛТЫН ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. МУИС-ийн Номын сангийн барилгын 202, 203, 302, 303, 502 тоот болон Хичээлийн 1 дүгээр байрны 217, 320 тоот танхимууд (цаашид "хурлын танхим" гэх)-ыг сургуулийн зохион байгуулалтын үйл ажиллагаанд ашиглаагүй, хичээл товлогдож зарлаагүй тохиолдолд лекц, семинар, зөвлөгөөн, чуулга уулзалт болон бусад үйл ажиллагааны зориулалтаар иргэн, хуулийн этгээдэд ашиглуулах харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Хурлын танхим ашиглалтын асуудлыг Хангамж үйлчилгээний газар (цаашид "ХҮГ" гэх) хариуцна.

### ХОЁР. ХУРЛЫН ТАНХИМЫГ АШИГЛАГЧ ТАЛ ХҮЛЭЭН АВАХ, ТАНХИМЫГ АШИГЛАХ, ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ

2.1. Хурлын танхим ашиглах хүсэлтэй иргэн, хуулийн этгээд хүсэлтээ үйл ажиллагаа зохион байгуулах өдрөөс 3-аас доошгүй хоногийн өмнө Хангамж үйлчилгээний газарт урьдчилан хандаж шийдвэрлүүлнэ.

2.2. Хурлын танхим ашиглах хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл хурлын танхимын ашиглах заавар, техник, тоног төхөөрөмж, цагийн хуваарьтай бүрэн танилцана.

2.3. Хурлын танхим ашиглах хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл хурлын танхим, цагийн хуваарийг ХҮГ-тай тохиролцож, зохих зөвшөөрөл авсны үндсэн дээр МУИС-ийн "Хурлын танхим ашиглалтын гэрээ" (цаашид "гэрээ" гэх)-г байгуулна.

2.4. Хурлын танхимыг ашиглуулах хугацааг доорх цагийн хуваарийг удирдлага болгон гэрээнд тодорхой заах бөгөөд шаардлагатай тохиолдолд танхим ашиглуулах хугацааг гэрээгээр сунгаж болно.

Ажлын өдөр: 08:30-18:30;

Бямба: 08:30-18:00;

Ням: 09:30-18:00.

2.5. Хурлын танхим ашиглагч нь үйл ажиллагаандаа зориулж нэмэлт техник, тоног төхөөрөмж бусад эд зүйл, баримт материалыг авч ирж болох бөгөөд танхим ашиглах хугацаа дуусахад тэдгээр зүйлсийг хурлын танхимыг сэвтээхгүй гэмтээхгүйгээр салган авч явна.

2.6. Хурлын танхим ашиглагч нь танхим хариуцсан ажилтнаас 2 хувь акт үйлдэн танхим болон эд хогшил, тоног төхөөрөмжийг хүлээн авч, ашиглаж дуусмагц тухайн өдрийн 19:00 цагийн дотор хурлын заалыг актанд гарын үсэг зурж, бүрэн бүтэн хүлээлгэн өгнө.

2.7. Номын сангийн танхимыг ашиглах тохиолдолд ХҮГ, номын сангийн зохион байгуулагч нар нь хурлын танхим ашиглагчаас тухайн үйл ажиллагаанд оролцох оролцогчдын тоог урьдчилан авч, нэвтрэх картыг тоо ширхгээр нь акт үйлдэн хурлын танхим ашиглагчид хүлээлгэн өгөх ба үйл ажиллагаа дууссаны дараа тоо ширхгээр нь хүлээн авч тэмдэглэл үйлдэнэ.

2.8. Хурлын танхим ашиглагч тал нэвтрэх картыг гээгдүүлсэн, гэмтээсэн тохиолдолд ХҮГ нь картны төлбөрийг нэхэмжилж, хохирлыг барагдуулах арга хэмжээ авна.

2.9. Хурлын танхимыг хүлээлгэн өгөх үед тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын хийц, төлөвлөлтийг зохих зөвшөөрөлгүйгээр өөрчилсөн, ердийн элэгдэл хорогдлоос илүү муутган бохирдуулсан эвдэлсэн, гэмтээсэн, хана, цонх, ханыг скоч болон цавуугаар бохирдуулсан тохиолдолд холбогдох засвар үйлчилгээ, цэвэрлэгээний төлбөрийг Хурлын танхим ашиглагчаас нэхэмжилж, учирсан хохирлыг мөнгөн төлбөрөөр нөхөн төлүүлнэ.

2.10. МУИС нь Хурлын танхимд үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээдийг интернэтийн үйлчилгээгээр хангах үүрэг хүлээхгүй.

#### ГУРАВ. АШИГЛАЛТЫН ТӨЛБӨР, ХӨНГӨЛӨЛТ

3.1 Хурлын танхим ашиглуулах төлбөр хураамжийг МУИС ийн Удирдах Зөвлөл батална. /Хавсралт-1/

3.2. Ашиглалтын төлбөрийг гэрээнд заасан хугацаагаар буюу үйл ажиллагаа эхэлсэн цагаас хурлын танхимыг ХҮГ-т хүлээлгэн өгсөн цагаар бодож тооцно.

3.3. Хурлын танхим ашиглагчийн зүгээс хугацаанаас нь өмнө цуцлах тохиолдолд төлбөрөөс дараах байдлаар суутгал хийнэ. Үүнд:

3.3.1. Ашиглах өдрөөс 48 цагийн өмнө цуцалбал гэрээний үнийн дүнгийн 50 хувийг суутгана.

3.3.2. 24 цагийн өмнө цуцалбал гэрээний үнийн дүнгийн 80 хувийг суутгана

3.3.3. Ашиглах өдөр өглөө цуцалбал гэрээний үнийн дүнг буцаан олгохгүй.

3.4. Ашиглагч тал үйл ажиллагаанаас 1 хоногийн өмнө тухайн үйл ажиллагаанд хэрэглэх эд, зүйлс, ачаа барааг хурлын танхимд хадгалуулах тохиолдолд нийт төлбөрийн 20 хувьтай тэнцэх төлбөрийг нэмж төлнө.

3.5. МУИС-ийн багш болон оюутан нар өөрийн бүрэлдэхүүн /салбар сургуулийн захирлын зөвшөөрлөөр эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагааг үнэ төлбөргүй явуулж болно.

3.6. МУИС-тай хамтран ажилладаг байгууллага, ивээн тэтгэгч байгууллага хурлын танхимыг ашиглах хүсэлт гаргасан тохиолдолд тухайн байгууллагатай байгуулсан "Хамтран ажиллах гэрээ" болон бусад холбогдох баримт бичгийг үндэслэн дэд захирлын шийдвэрээр төлбөрийг 50 хүртэлх хувиар хөнгөлж болно.


## ДӨРӨВ. ХОРИГЛОХ ЗҮЙЛ

4.1. Хурлын танхимд шашны, сүм хийд, улс төрийн үйл ажиллагаа эрхлэн явуулахыг хориглоно.

4.2. Хурлын танхим ашиглах үед танхимын хаалга, цонх, хана дээр үзүүлэн болон бусад материалыг скоч, цавуугаар нааж бохирдуулахыг хатуу хориглоно.

4.3. Хурлын танхимд болон түүний ойролцоо галт зэвсэг, шатамхай бодис, шатамхай материал, дэлбэрэх зүйл, хорт бодис, хурц үнэртэй зүйл, түлш болон химийн бодис зэрэг аюултай зүйлсийг хадгалах, авчрахыг хориглоно.

х х х х



Захирлын 2019 оны 02 дугаар сарын 28-ны  
өдрийн 1 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

### БАТЛАВ

МУИС-ийн Санхүү, төлөвлөлт хариуцсан \_\_\_\_\_  
дэд захирал Ч.Ундрэм \_\_\_\_\_

[Гарын үсэг] \_\_\_\_\_ [Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

ТАМГА

Улаанбаатар хот СБД 6-р хороо \_\_\_\_\_

### ХУРЛЫН ТАНХИМ АШИГЛАЛТЫН ГЭРЭЭ

20\_\_ оны \_\_ сарын \_\_ өдөр

№ \_\_\_\_\_

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг Монгол Улсын Иргэний хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтыг болон “МУИС-ын танхим ашиглалтын журам”-ыг үндэслэн Нэг талаас Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Их сургуулийн гудамж-1 хаягт орших **Монгол Улсын Их Сургууль** (РД: **9104399** цаашид “танхим ашиглуулагч” гэх), түүнийг төлөөлж тус байгууллагын **Хангамж үйлчилгээний газрын дарга В.Алтансүх**,

Нөгөө талаас Улаанбаатар хот, \_\_\_\_\_ дүүрэг, \_\_\_\_-р хороо, \_\_\_\_\_ хаягт орших \_\_\_\_\_ (РД: \_\_\_\_\_ цаашид “танхим ашиглагч”, гэх) түүнийг төлөөлж \_\_\_\_\_ нар (хамт нь “талууд” гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү гэрээгээр танхим ашиглуулагч нь Сүхбаатар дүүргийн 6 дугаар хороо, номын сангийн байрны \_\_\_\_\_ тоот, \_\_\_\_\_ метр кв талбай (цаашид “танхим” гэх)-г \_\_\_\_\_ зориулалтаар танхим ашиглагчид хүлээлгэн өгөх, танхим ашиглагч нь шашны, сүм хийд, улс төрийн үйл ажиллагаа

эрхлэн явуулахгүйгээр, танхимыг гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглах, уг гэрээнд дурдсан нөхцөлөөр ашиглалтын төлбөр төлөхтэй холбоотой талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг зохицуулахад оршино.

### ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

2.1. Гэрээний хугацаа 20\_\_\_ оны \_\_\_ дүгээр сарын \_\_\_-ны өдрийн \_\_\_ цагаас эхлэн 20\_\_\_ оны \_\_\_ дүгээр сарын \_\_\_-ны өдрийн \_\_\_ цаг \_\_\_ минутыг дуустал үргэлжилнэ.

2.2. Талууд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй тохиолдолд Гэрээг цуцлах саналаа 48 цагаас доошгүй хугацааны өмнө нөгөө талдаа албан бичгээр мэдэгдэж гэрээний заасны дагуу төлбөр тооцоог эцэслэнэ.

### ГУРАВ. ТӨЛБӨР ТООЦОО ХИЙХ НӨХЦӨЛ

3.1. Танхимын \_\_\_ өдөр, \_\_\_ цаг, \_\_\_ минутын төлбөр нийт \_\_\_\_\_ төгрөг байх бөгөөд үүнд НӨАТ болон бусад бүх зардал орсон болно.

3.2. Танхим ашиглагч нь гэрээ батлагдсан өдөр нийт төлбөрийн 80 хувийн урьдчилгаа төлнө. Хурлын үйл ажиллагааны өмнө үлдсэн төлбөрийг төлж барагдуулна.

3.3. Төлбөрийг бэлнээр эсхүл бэлэн бусаар хийнэ. Бэлэн бусаар тооцоо хийх тохиолдолд танхим ашиглуулагчаас нэхэмжлэл авч нэхэмжлэлийн дагуу **Монгол Улсын Их Сургуулийн Голомт банкин дахь 1102027741 тоот эсвэл Хаан банкин дахь 5041078723 тоот** төгрөгийн дансанд шилжүүлнэ.

3.4. Танхим ашиглагч нь хурлын өмнө урьдчилаад төлбөрөө 100 хувь төлж болно.

3.5. Хурлын танхим ашиглагч нь гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах тохиолдолд танхим ашиглуулагч нь төлбөрөөс дараах байдлаар суутгал хийнэ. Үүнд:

3.5.1. Гэрээнд заасан хугацаанаас 48 цагийн өмнө гэрээг цуцалсан тохиолдолд нийт төлбөрийн 50 хувийн суутгаж авна.

3.5.2. 24 цаг буюу 1 өдрийн өмнө гэрээг цуцалсан тохиолдолд нийт төлбөрийн 80 хувийг суутгаж авна.

3.5.3. Үйл ажиллагаа эхлэх өдөр гэрээг цуцалсан тохиолдолд гэрээний төлбөрийг 100 хувь авна.

### ДӨРӨВ. ХУРЛЫН ТАНХИМЫГ АШИГЛАХ НӨХЦӨЛ

4.1. Хурлын танхим ашиглуулагч нь танхим ашиглагчид танхим, танхимд нэвтрэх карт болон танхимын эд хогшлуудыг акт үйлдэн хүлээлгэн өгөх ба гэрээний хугацаа дуусахад актын дагуу хүлээн авна.

4.2. Хурлын танхим ашиглагч нь байрыг хүлээн авах үед байсан байдал төрхөөр нь эд хогшил, тоног төхөөрөмжийг бүрэн бүтэн байдлаар нь танхим ашиглуулагчид хүлээлгэн өгнө.

4.3. Хурлын танхим ашиглагч үйл ажиллагаанаас 1 хоногийн өмнө түүнд хэрэглэх эд, зүйлс, ачаа барааг хурлын танхимд хадгалуулах мөн бэлтгэл хийх шаардлагатай бол Хурлын танхим ашиглуулагчаас зөвшөөрөл авах бөгөөд нийт төлбөрийн 20%-тай тэнцэх төлбөрийг төлнө.

4.4. Танхим Ашиглагч тал үйл ажиллагаатай холбогдуулж танхимын хаалга, цонх, хананд үзүүлэн, материалыг скоч, цавуугаар наахыг хатуу хориглоно.

4.5. Ашиглах танхимд үзүүлэн самбар мэдээллүүдийг өлгөхдөө Хурлын танхим ашиглуулагчийн бэлдсэн самбарыг ашиглах эсвэл өөрсдөө самбартай /эвхдэг/ ирнэ.

#### ТАВ. ТАНХИМ АШИГЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1 Танхим Ашиглалтын төлбөрийг энэхүү гэрээний 3 дугаар зүйлд заасны дагуу төлбөрийг цаг хугацаанд нь төлж барагдуулах үүрэгтэй.

5.2 Хурлын танхим ашиглагч тал хурлын танхимын зохион байгуулалтад өөрчлөлт оруулах бол заавал урьдчилан мэдэгдэж харилцан тохиролцож бичгээр зөвшөөрөл авах үүрэг хүлээнэ.

5.3 Танхим болон бусад эд хөрөнгийг энэхүү гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглах ба танхим, түүний доторх эд хөрөнгө, харуул хамгаалалт, аюулгүй байдал, бүрэн бүтэн байдлыг ашиглуулсан цагаас эхлэн Хурлын танхим ашиглагч тал бүрэн хариуцна. Үндсэн хөрөнгийн элэгдлээс гадна аливаа тоног төхөөрөмж, эд хогшилд ямар нэгэн эвдрэл гэмтэл, хорогдол гарсан тохиолдолд уг хохирлыг мөнгөн төлбөрөөр барагдуулах үүрэгтэй.

5.4 Хурлын танхим ашиглагч нь Ашиглалтын талбайд болон түүний ойролцоо галт зэвсэг, шатамхай бодис, шатамхай материал, тэсэрч дэлбэрэх зүйл, хорт бодис, хурц үнэртэй зүйл, түлш болон химийн бодис зэрэг аюултай зүйлсийг хадгалах, авчрахыг хориглоно.

5.5 Хурлын танхим ашиглагч нь өөрийн санаатай бөгөөд гэм буруутай үйлдэл, эс үйлдэл, хайхрамжгүй үйлдэл, эс үйлдлийн улмаас эд хөрөнгө, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсантай шууд холбоотойгоор Хурлын танхим ашиглуулагчийн эсрэг гарсан эсхүл Хурлын танхим ашиглуулагчид учирсан хохирол, алдагдал, мөнгөн төлбөр, хариуцлагын шаардлагаас Хурлын танхим ашиглуулагчийг чөлөөлөх, хамгаалах, хохиролгүй болгох үүрэгтэй.

5.6 Танхим ашиглах хугацаандаа эд хогшлыг дамжуулан түрээслэх, барьцаалах, бусдад шилжүүлэх, баталгаа гаргахыг хориглоно.

5.7 Танхим ашиглах хугацаа дуусгавар болоход өөрийн хөрөнгөөр авсан эд хогшил, тоног төхөөрөмжийг түрээслүүлэгчийн байр, эд хөрөнгийг сэвтээхгүй, гэмтээхгүй нөхцөлд салган авч болно.

5.8 Танхим ашиглуулагчаас гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.

#### ЗУРГАА. ТАНХИМ АШИГЛУУЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

6.1. Гэрээнд заасан хугацаанд танхим, эд хогшлыг хүлээлгэн өгч, Хурлын танхим ашиглагчийг хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөлөөр хангах үүрэгтэй.

6.2. Хурлын танхим ашиглуулагч тал хурлын танхимын зохион байгуулалтад өөрчлөлт оруулах бол нөгөө талдаа заавал урьдчилан мэдэгдэж, харилцан зөвшилцөх үүрэг хүлээнэ.

6.3. Гэрээний дагуу Хурлын танхимд ашиглахаар тохиролцсон эд хогшил буюу проектор, дэлгэц, ухаалаг индэр зэрэг тоног төхөөрөмж болон эд хөрөнгийг ямар нэгэн доголдолгүйгээр актын дагуу танхим ашиглагчид хүлээлгэн өгөх үүрэгтэй.

6.4. Ашиглуулахаар актын дагуу хүлээлгэн өгсөн эд хогшилд Хурлын танхим ашиглагчаас үл хамаарах шалтгаанаар эвдрэл гэмтэл гарвал түүний үр дагаврыг арилгах арга хэмжээг яаралтай авах үүрэгтэй.

6.5. Танхим ашиглагчаас төлбөрөө хугацаанд нь төлөхийг шаардах эрхтэй.

6.6. Танхим ашиглагчийн буруутай үйл ажиллагааны улмаас танхимд эвдрэл, гэмтэл гарсан тохиолдолд хохирлыг мөнгөн төлбөрөөр барагдуулахыг шаардах эрхтэй.

6.7. Танхим ашиглагчаас гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах эрхтэй.

6.8. Танхим ашиглагч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн буюу зохих ёсоор биелүүлээгүй бол гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж, учирсан хохирлыг нэхэмжлэх эрхтэй.

#### ДОЛОО. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

7.1. Талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс нөгөө талдаа учирсан хохирлыг бүрэн хариуцна.

7.2. Хурлын танхим ашиглагч тал нь төлбөрийг гэрээний 3 дугаар зүйлд заасан хугацаанд нь төлөөгүй бол төлөөгүй үнийн дүнгээс хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөгдөөгүй үнийн дүнгээс 0.5 хувийн алданги төлнө.

7.3. Хурлын танхим ашиглуулагч тал гэрээнд заасан хугацаанд хурлын танхимыг танхим ашиглагч талд шилжүүлэн өгөөгүйгээс гарах хохирлыг бүрэн хариуцах ба цаг тутамд ашиглалтын нийт төлбөрийн 0,5 хувиар тооцож торгууль төлнө.

7.4. Хурлын танхимыг энэхүү гэрээний 1.1-д заасан зориулалтаар ашиглах ба бусад хуулийн этгээдэд давхар түрээслүүлэхгүй байх ба зориулалтын бусаар ашигласан, хууль бусаар ашиглавал танхим ашиглуулагчийн санаачилгаар гэрээг цуцална.

#### НАЙМ. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ БОЛОН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

8.1 Хурлын танхим ашиглуулагчаас ашиглалтын гэрээг дараах тохиолдолд нэг талын санаачилгаар, ашиглалтын гэрээний хугацаа дуусахаас өмнө цуцалж болно.

8.1.1 Ашиглалтын төлбөр төлөх хугацаа хэтэрсэн;

8.1.2 Хурлын танхим ашиглагч шашны гаж урсгал, улс төрийн ноцтой акц үйлдэх гэж байгаа нь илэрвэл;

8.1.3 Хурлын танхим ашиглагч Хурлын танхим ашиглуулагчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр Ашиглалтын талбайг бусдад дамжуулан ашиглуулсан, шилжүүлсэн;

8.1.4 Ашигласан эд хөрөнгийг гэрээнд заасан зориулалтын дагуу эзэмшиж ашиглаагүй, Хурлын танхим ашиглуулагчийн тавьсан шаардлагыг үндэслэлгүйгээр 2 буюу түүнээс дээш удаа биелүүлээгүй.

8.2 Хурлын танхим ашиглагчийн санаачилгаар түрээсийн гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно. Энэ тохиолдолд энэхүү гэрээний 3.5-д заасны дагуу төлбөрөөс суутгал хийнэ.

#### ЕС. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

9.1 Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх аргаар шийдвэрлэнэ.

9.2 Хэрэв Гэрээний 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасан аргаар маргааныг шийдвэрлэж чадахгүй бол Монгол улсын хууль тогтоомжид заасны дагуу Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### АРАВ. ГЭНЭТИЙН БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

10.1 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ хэсгээр ба бүрнээр зохих ёсоор биелүүлээгүй бөгөөд энэ нь гэрээ хүчин төгөлдөр болсны дараа онцгой шинж чанар бүхий үйл явдлын үр дүнд бий болсон, талууд урьдчилан мэдэх, болгоомжлох боломжгүй байсан бол талууд төлбөрийг харилцан тохиролцож болно.

10.2 Гэрээнд заасан онцгой шинж чанар бүхий үйл явдалд үерт автах, гал, газар хөдлөх, дэлбэрэх, хүчтэй салхи, шуурга, газар нурах, суух, тахал болон бусад байгалийн хүчин зүйлс, мөн дайн, цэргийн үйл ажиллагаа нь энэ гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгоход хамаарна.

#### АРАВ НЭГ. ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЖУРАМ

11.1 Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцож нэмэлт гэрээ байгуулах замаар шийдвэрлэнэ.

11.2 Гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

11.3 Гэрээний нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

#### АРВАН ХОЁР. БУСАД ЗҮЙЛ

12.1 Гэрээ нь талуудын бүрэн эрхт төлөөлөгчид гарын үсэг зурж, тэмдэг (тамга) дарснаар хүчин төгөлдөр болно.

12.2 Гэрээг гурван хувь үйлдэж, танхим ашиглуулагч тал хоёр хувийг, танхим ашиглагч тал нэг хувийг авах бөгөөд хувь тус бүр нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

12.3 Талууд гэрээнд тусгагдаагүй асуудлыг шийдвэрлэхдээ Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөнө.

12.4 Хэрэв энэхүү Гэрээний хугацааг Талууд харилцан тохиролцож сунгаагүй тохиолдолд энэхүү гэрээ нь Гэрээнд дурдагдсан өдөр хүртэл хүчин төгөлдөр байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ТАНХИМ АШИГЛУУЛАГЧИЙГ  
ТӨЛӨӨЛЖ:

Хангамж Үйлчилгээний Газрын  
Дарга В.Алтансүх

[Гарын үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

Улаанбаатар хот СБД 6-р хороо  
Утас: 11-321983

ТАНХИМ АШИГЛАГЧИЙГ  
ТӨЛӨӨЛЖ:

\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

[Гарын үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

Улаанбаатар хот ....., .....-р хороо  
Утас: